



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/697

Ховд

Газар зүйн нэрийн салбар  
зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.6, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 186 дугаар зарлиг, Улсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоол, Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.1, 5.8.2, 5.8.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн “Газар зүйн нэрийн салбар зөвлөл”-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Салбар зөвлөлийн дарга:

-Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд:

-Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга

-Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга

-Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

-Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

-Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга

-Цагдаагийн газрын дарга

-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

02 03424  
Зах-А/697/Ch

- Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
- Боловсрол, соёл, урлагийн газрын дарга
- “Хар нуур-Ховд голын” сав газрын захиргааны дарга
- Үенч, Бодонч, Булган голын сав газрын захиргааны дарга
- Хар-Ус нуур орчмын УТХГН-ын хамгаалалтын захиргааны дарга
- Хилийн цэргийн 0130 дугаар ангийн захирагч
- Авто тээврийн төвийн дарга
- “Мэдээлэл, холбоо сүлжээ” ТӨХК-ний Ховд салбарын дарга
- “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн Ховд салбарын дарга

Нарийн бичгийн дарга:

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн

2.“Газар зүйн нэрийн салбар зөвлөл” байгуулахтай холбогдуулан 17 суманд зөвлөл байгуулах тухай заавар, зөвлөмжийг хүргүүлж, хийгдэх ажлын төлөвлөгөө боловсруулан мөрдөж ажиллахыг /Салбар зөвлөлийн дарга/-д даалгасугай.

3.Газар зүйн нэрийн хээрийн тодруулалтыг аймгийн хэмжээнд хийх ажлыг зохион байгуулах, газар зүйн нэрийн мэдээллийн сан бүрдүүлэх, шинээр өгөх болон өөрчлөх газар зүйн нэрийг хэлэлцэн “Газар зүйн нэрийн зөвлөл”-д хүргүүлэх болон эдгээр ажлуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тухайн жилийн төсөвт тусгах замаар тухай бүрд шийдвэрлэн ажиллахыг Салбар зөвлөл болон Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ